

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэгдүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт:

3.1.4.“судалгааны байгууллага” гэж паркт шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, туршилт, зохион бүтээх ажил явуулах, дэвшилтэт техник, технологийг дамжуулах, нутагшуулах үүрэг бүхий байгууллагыг;

2/ 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:

10.7.парк нь сургалт, судалгааны болон бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай байна.

3/ 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт:

11.1.4.паркийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах зөвшөөрлийг гэрээний үндсэн дээр олгох;

4/ 14 дүгээр зүйл:

14 дүгээр зүйл. Паркт үзүүлэх татварын болон бусад дэмжлэг

14.1.парк дараах дэмжлэгийг үзүүлнэ:

14.1.1.үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 10 жилд 50 хувиар хөнгөлнө.

14.1.2.үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг газрын төлбөрөөс эхний 10 жилд чөлөөлнө.

14.1.3.үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн паркт эрхэлж байгаа үйл ажиллагаанаас олсон орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

14.1.4.паркийн удирдлага, нэгжид Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан дэмжлэгүүд хамаарна.

5/ 15 дугаар зүйл:

15 дугаар зүйл. Паркийн үйл ажиллагааны орлого

15.1.Паркийн үйл ажиллагааны дараах орлогыг Улсын төсөвт төвлөрүүлнэ:

15.1.1.парк дахь аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орлогын албан татвар;

15.1.2.парк дахь төрийн өмчийн барилга байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр;

15.1.3.газрын төлбөр;

15.1.4.бусад;

15.2.Паркийн удирдлага нь дараах орлогыг үйл ажиллагаандаа зарцуулна:

15.2.1.өөрийн үйл ажиллагааны орлого;

15.2.2.паркийн нэгжид үйлчилгээ үзүүлсний хураамж;

15.3.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр байгуулсан паркийн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрийн жагсаалт, паркийн нэгжийн хураамжийн хэмжээ, төлөх журмыг үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

15.4.хувийн болон төр, хувийн хэвшлийн оролцоотой хөрөнгөөр байгуулсан паркт өөрийн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрийн жагсаалт, паркийн нэгжийн хураамжийн хэмжээг паркийн нэгжтэй байгуулах гэрээнд тусгана.

15.5.Энэ хуулийн 15.1-д заасан орлогын 20 хүртэл хувийг паркийг хөгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг түргэтгэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор зарцуулна.

Хоёрдугаар зүйл.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт:

3.1.3.“паркийн нэгж” гэж паркийн удирдлагатай байгуулсан гэрээний үндсэн дээр паркийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, бизнес инкубаци, сургалт, судалгааны болон бусад байгууллагыг;

2/ 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт:

7.1 дэх хэсгийн эхний “Хөнгөн үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэл, технологийн паркийн” гэж өөрчилсүгэй.

3/ 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

10.3 дахь хэсгийн “5” гэснийг “15”,

10.6 дахь хэсгийн “5” гэснийг “15” гэж тус тус өөрчилсүгэй.

4/ Дөрөвдүгээр бүлэг

“14 дүгээр зүйл” гэснийг “16 дугаар зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

Гуравдугаар зүйл.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2018 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар
сарын . . . өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй.

1/ 16 дугаар зүйлийн 16.1.15 дахь заалт
16.1.15. үйлдвэрлэл, технологийн паркийн газар

2/ 22² дугаар зүйл.

22² дүгээр зүйл. Паркийн удирдлагын бүрэн эрх
22².1.үйлдвэрлэл, технологийн паркийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу паркийн газрыг аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулна.

Хоёрдугаар зүйл. Газрын тухай хуулийн 18.1.2 дахь заалтын “16.1.14” гэсний дараа ,“16.1.15”, 19.1.6 дахь заалтын “16.1.12” гэсний дараа ,“16.1.15” гэж тус тус нэмсүгэй.

Гуравдугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар
сарын . . . өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 8.1.9. үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг газрын төлбөрөөс эхний 10 жилд чөлөөлнө.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар
сарын . . . өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.2.4 дэх заалт нэмсүгэй:

1/ 7.2.4. үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 10 жилд 50 хувиар хөнгөлнө.

Хоёрдугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гуравдугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар
сарын . . . өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Нэгдүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй.

1/ 18 дугаар зүйлийн 18.1.16 дахь заалт:

18.1.16. үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн паркт эрхэлж байгаа үйл ажиллагаанаас олсон орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар
сарын . . . өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 20.12.“аж үйлдвэрийн” гэснийг “үйлдвэрлэл, технологийн” гэж.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар
сарын . . . өдөр

Улаанбаатар
хот

ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй.

1/ 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт:

7.1.2.Боловсруулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах.

Хоёрдугаар зүйл. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн заалтуудын дугаарыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2/ 7 дугаар зүйлийн “7.1.2” гэснийг 7.1.3, “7.1.3” гэснийг 7.1.4, “7.1.4” гэснийг 7.1.5, “7.1.5” гэснийг 7.1.6, “7.1.6” гэснийг 7.1.7, “7.1.7” гэснийг 7.1.8, “7.1.8” гэснийг 7.1.9 гэж өөрчилсүгэй.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ